



АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн  
санхүүжилтээр хэрэгжиж буй “ Бизнесийн  
тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил тод  
байдлыг нэмэгдүүлэх BEST хөтөлбөр”-ийн  
Сэлэнгэ салбарын 2022 оны хагас жилийн үйл  
ажиллагааны тайлан

2022 он



## BEST хөтөлбөр

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг ( USAID )-ийн санхүүжилтээр Хөгжлийн Шийдэл ТББ нь “Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил тод байдлыг нэмэгдүүлэх BEST хөтөлбөрийг Улаанбаатар хот болон Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл, Завхан, Баянхонгор, Ховд, Дорнод, Хэнтий, Дорноговь, Өмнөговь гэсэн 13 салбар нэгжээр дамжуулан бизнес эрхлэгчдэд хүрч ажиллаж байна.

### Хөтөлбөрийн зорилтууд :

1. ЖДБ-н санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх
2. ЖДБ-н засаглалыг сайжруулах
3. ЖДБ-н үйл ажиллагааг дэмждэг Төрийн болон ТББ-н ил тод байдлыг хангах
4. Бизнесийн хөгжлийн стратегийг тодорхойлоход чиглэсэн судалгааг хийх
5. Цаашид тогтвортой хөгжих боломжтой, санхүүжилт авах чадамжгүй ТББ, ЖДБ гарааны бизнес эрхлэгчдэд бичил санхүүжилт олгох зэрэгт оршино.

### Хөтөлбөрийн зорилго :

Жижиг, дунд бизнесүүдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн хариуцлага, ил тод байдлыг сайжруулах замаар Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд чиглэнэ.

Сэлэнгэ салбарын хувьд Сэлэнгэ аймгийн ЗДТГ, Хүнс Хөдөө Аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс, Стандарт хэмжил зүйн хэлтэс гэсэн төрийн байгууллагууд болон Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж буй арилжааны Хас, Хаан, Төр, Голомт банк болон бусад Неткапитал, Бэрс финанс ББСБ-тай хамтран ажиллаж орон нутагт үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдийг дэмжин хамтран ажиллаа.

### Зээлийн зуучлал :



Зуучилсан нийт зээл

128 ЖДБ-д 12,1 тэр бум

Батлагдсан нийт зээл

92 ЖДБ 9,3 тэр бум



## Сургалтын модуль Зорилт-1 :

1. Бизнес төсөл боловсруулах
2. Зээл санхүүгийн боловсрол
3. НББ
4. Сошиал медиа маркетинг

Гэсэн 4 модулийн хүрээнд нийт 1 удаагийн сургалт, 6 удаагийн уулзалтыг 810 оролцогчдод, оролцогч талуудын уулзалтыг 3 удаагийн уулзалтыг 58 оролцогчдод Сэлэнгэ аймгийн Хүнс Хөдөө Аж Ахуйн газар, Татварын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулдаг арилжааны Хас, Хаан, Төр, Голомт банк зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө гарган сар бүр тогтмол сургалт зохион байгуулан ажиллаа.

**Онцлох мэдээ :** 2022 оны 5-р сарын 09-с 24-ний өдрүүдэд Сэлэнгэ аймгийн ЗДТГ болон Сэлэнгэ аймгийн ХХААГ-тай хамтран Сэлэнгэ аймгийн 17 сум 1 тосгоны нийт 230 бизнес эрхлэгчдэд “Бизнес төсөл боловсруулах сургалт” “Хоршоо хөгжүүлэх сангийн шинэчилсэн журам, ЖДҮ сангийн шинэчилсэн журам”-ын талаарх мэдээлэл өгөх сургалтыг сум бүрд очиж танхимын сургалтыг сум бүрийн ЗДТГ-тай хамтран амжилттай зохион байгуулж ажиллаа.

## Зорилт-2 :

Компанийн засаглалын чиглэлээр нийт 9 удаагийн сургалт, 8 удаагийн уулзалтыг 719 оролцогчдод зохион байгуулж ажилласан байна. Сургалт, уулзалтын төлөвлөгөөг BEST хөтөлбөрийн зорилт хариуцсан зохицуулагч болон орон нутгийн салбаруудын зорилт хариуцсан зөвлөхүүдтэй хамтран зохион байгуулан ажиллаа.

**Онцлох мэдээ :** Сэлэнгэ аймгийн ХХААГазар, Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран цахимаар Сэлэнгэ аймгийн 17 сумдад хүнс үйлдвэрлэл, нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 255 бизнес эрхлэгчдэд “ Зохистой дадлыг хэвшүүлэх, дотоод хяналтыг төлөвшүүлэх нь ” сэдвээр хамтарсан сургалтыг амжилттай зохион байгуулж ажиллаа.

## Зөвлөх үйлчилгээ :

Богино хугацааны зөвлөх үйлчилгээг 15 ААН-д

Урт хугацааны зөвлөх үйлчилгээг 3 ААН-д үзүүлэн ажиллаа.



### **Зорилт-3 :**

Зорилт-3 хүрээнд Сэлэнгэ аймгийн ЗДТГ-н Хууль, Эрх зүйн хэлтэстэй хамтран ТАХ-д зориулсан сургалтыг зохион байгуулж хамтран ажиллаж байна. Мөн Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулдаг идэвхтэй 3 ТББ-тай хамтран ажиллаж сургалтад хамруулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд нийт ТББ-г чадавхжуулах сургалт 1, уулзалтыг 2 удаа нийт 40 оролцогч, Төрийн албан хаагчдад зориулсан 2 удаагийн сургалтыг 35 оролцогчдод зохион байгуулсан.

Мөн Сэлэнгэ аймгийн бизнесийн орчны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох судалгааг Улаанбаатар хотын судалгааны мэргэжлийн багаар хийлгэсэн. Судалгааны тайланг 2022 оны 8-р сард орон нутгийн удирдлагуудад танилцуулна.

### **Зорилт-5 :**

Тэтгэлэг Сэлэнгэ аймгаас нийт 35 горилогч хүсэлт ирүүлснээс эхний шатанд 22 горилогчийн хүсэлт шалгарсан. 2022.01-2023.03 сар хүртэлх хугацаанд горилогчид хурдасгуур хөтөлбөрт хамрагдсан эцсийн сонгон шалгаруулалтад оролцсон. Сэлэнгэ аймгаас 1 гарааны бизнес, 3 ЖДБ шалгаран 40,0 сая төгрөгийн тэтгэлэг авсан. Тэтгэлэг авсан гарааны 1 бизнес албан бизнес болж үйл ажиллагаа эхлүүлсэн.